



ӨМНӨГОВЬ АЙМАГ
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 11 өдөр

Дугаар А/17

Даланзадгад

Эрт илрүүлэг зохион байгуулах
тухай

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/139 дүгээр тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 2/3, 2/4 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Засаг даргын 2020-2024 оны “Нутгийн хишиг” хөтөлбөрийн 136 дахь заалт, Аймгийн Засаг Даргын А/384 дүгээр захирамжийн хэрэгжилтийг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Иргэн бүрийг жил бүр урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах үйл ажиллагааг арга зүй, удирдлага, төлөвлөлт зохион байгуулалтаар хангаж арга хэмжээний төлөвлөгөөг батлуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, төсөв санхүүгийн асуудалд хяналт тавьж, шийдвэрлүүлж ажиллахыг Удирдлага төлөвлөлт санхүүгийн хэлтэс (М.Цэндсүрэн)-т, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга эрхлэгч нарт үүрэг болгосугай.

2. Урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо, шинжилгээний үйл ажиллагааг анхан шатны болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагатай хамтран удирдан зохион байгуулж, шаардлагатай эм эмнэлгийн хэрэгсэл урвалж, оношлуурын нөөц, хангалтыг бүрдүүлэх, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжид хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн хэлтэс (Ж.Отгонбайгал)-т, Бүсийн оношилгоо эмчилгээний төв (Д.Түвшинзул)-д үүрэг болгосугай.

3. Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдвал зохих хүн амын судалгааг гаргах, иргэдийг өргөнөөр хамруулах, зөв эерэг мэдээллийг иргэдэд түгээх, илэрсэн өвчлөлийн судалгаа, сэргийлэх арга замыг судлан

танилцуулах ажлыг Нийгмийн эрүүл мэндийн төв (Б.Амгалан)-д, сум, өрхийн эрүүл мэндийн байгууллагын нийгмийн ажилтан нарт үүрэг болгосугай.

4. Эрт илрүүлэг арга хэмжээний мэдээ, тайланг нэгтгэн тайлагнах, хяналт тавьж ажиллахыг сум, өрхийн эрүүл мэндийн байгууллагын дарга, эрхлэгч нарт, аймгийн хэмжээнд эрт илрүүлгийн цахим бүртгэлийн мэдээллийн сан үүсгэх, тайлан мэдээг нэгтгэж танилцуулах, явцын хяналт үнэлгээ хийх ажлыг Хяналт, шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтэс (Б.Мидэрсүрэн)-д тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж тулгамдсан болоод анхаарах асуудлыг танилцуулж шийдвэрлүүлэх ажлыг Хяналт, шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтэс (Б.Мидэрсүрэн)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.ШИЖИРТУЯА

